



БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.03.16 № 15

Ерөнхий боловсролын сургуулийн
хувьсах зардлын талаар

Миний бие Улсын Их Хурлын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд хангайн бүсийн тойрогт ажиллахдаа иргэд сонгогчид, төрийн албан хаагчидтай уулзсан. Уулзалтаар боловсролын салбарт тулгамдаж буй боловсролын чанар, хүртээмж, хичээлийн байр, суралцах орчин, багш ажилчдын цалин, багш нарын мэдлэг, ур чадвар, суралцагчдын сурлагын чанар, бага ангийн хүүхдүүдийн үдийн цай, хөтөлбөрийн хүртээмж гэхчлэн шийдвэрлэх ёстой олон асуудлыг хөндөж байсан.

Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг буюу 819,907 суралцагч ерөнхий боловсролын 900 сургуульд 2025-2026 оны хичээлийн жилд суралцаж байна. Энэ том “айл”-ын эрх зүйн орчныг зохицуулж буй гол хууль болох Боловсролын ерөнхий хуулийн зарим зохицуулалтыг эргэн харах зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан холбогдох судалгаа шинжилгээг хийж байна.

Боловсролын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.5 дахь заалт “Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид олгох сургалтын шууд өртөгт суурилсан зардлын санхүүжилтийн хэмжээг байршил, сургалтын төлбөрийн хэмжээтэй уялдуулан Засгийн газар тогтоох бөгөөд санхүүжилт авах суралцагчийн тоогоор олгох.” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн үйл ажиллагааны дараах зардлын бүрэлдэхүүнийг харгалзан тооцож, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.” хэмээн тус тус заасан байх ба энэхүү хуулийн зохицуулалтын хүрээнд улсын төсвөөс олгож буй нэг суралцагчид ногдох хувьсах зардалтай холбоотойгоор мэдээлэл шаардагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

1.Ерөнхий боловсролын нийт сургуулиудыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой Засгийн газрын баримталж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний талаар;

2026000043

2.Улсын төсвөөс санхүүжиж буй төрийн өмчийн болон төрийн бус, их, дээд сургуулиудын харьяа ерөнхий боловсролын сургуулиудын дэлгэрэнгүй тоон мэдээлэл;

3.2020-2025 онд төрийн өмчийн болон төрийн бус, их, дээд сургуулиудын харьяа ерөнхий боловсролын сургуулиудад улсын төсвөөс олгосон санхүүжилтийн дэлгэрэнгүй мэдээлэл;

4.2026 онд төрийн өмчийн болон төрийн бус, их, дээд сургуулиудын харьяа ерөнхий боловсролын сургуулиудад улсын төсвөөс олгох санхүүжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 11.2-т заасан хугацаанд хариу ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.АЛТАНГЭРЭЛ

2028000043